1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9105352*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*НД 4Х*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Авто зам*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1.5.1) Налайх дүүргийн засаг даргын тамгын газар 2025-08-07-ны өдрийн 04/1601 тоот албан бичиг* *1.5.2) Архитектур төлөвлөлтийн 2025оны 2025/00-108 дугаартай даалгавар, батлагдсан эскиз зураг.* *1.5.3) УБЦТС ТӨХК НТТ-ын 2025-06-30-ны өдрийн зураг төсөлд тодруулга хийсэн тодорхойлолт*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Инженерийн байгууламж*
1.7	**Суурилагдсан хүчин чадал**	*2 кВА* *(Хоёр кВА)*
1.8	**Хүчдэлийн түвшин**	*380В*

Хоёр. Холболтын цэг

2.1	110/35/10 кВ-ын Налайх дэд станцын, 10 кВ-ын Аврах фидерийн АТП-7012 дэд өртөөний 0.4 кВ талд рубильник бүхий групп тоноглож бүрээстэй агаарын шугам /кабель шугам/ татаж авто замын гэрэлтүүлгийн щитийг тэжээх.
2.2	110/35/10 кВ-ын Налайх дэд станцын, 10 кВ-ын Тосгон фидерийн АТП-7036 дэд өртөөний 0.4 кВ талын зүүн урд гаргалгын 4-р тулгуураас бүрээстэй агаарын шугам /кабель шугам/ татаж авто замын гэрэлтүүлгийн щитийг тэжээх.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.
3.2	0.4 кВ-ын гэрэлтүүлгийн щитэнд 16 А-ийн дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж, /УЗО/, DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон, 100 А-ийн тоолуур суурилуулах.
3.3	Шинээр суурилуулах тоолуурыг угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС

	ТӨХК-ийн Хангах үйл ажиллагаа, тоолуурын бодлогын хэлтэстэй зөвшилцөх

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Төлөвлөж байгаа замын хэсэгт дараах агаарын болон кабель шугам, тулгуурууд, дэд өртөө нь авто замын трасстай давхацсан, зам хөндлөн гарсан, ойртсон тул батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөх Үүнд: 4.1.1) 6, 10 кВ-ын кабель шугамууд: - 110/35/10 кВ Налайх дэд станцаас 10 кВ-ын Дулаан фидерийн 1 ширхэг кабель шугам авто замын трасст орсон тул эдгээр шугамыг батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх. 4.1.2) 6, 10 кВ-ын агаарын шугам: - 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Тосгон фидерийн тулгуур №17-18 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон - 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Аврах фидерийн тулгуур №15-16 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон - 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Уурхай фидерийн тулгуур №9, 10, 11, 12, 13 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон - 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Эрдэс фидерийн тулгуур №11, 12, 13, 14, 15 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон тул агаарын шугамаар батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх. 4.1.3) -0.4 кВ-ын агаарын шугам: АТП-7036 дэд өртөөний 0,4 кВ-ын зүүн гаргалгын тулгуур № 8, 9, 10, 50, 51 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон АТП-7012 дэд өртөөний 0,4 кВ-ын урд гаргалгын тулгуур № 6, зүүн гаргалгын тулгуур № 5-с урагш салбар тулгуур №6 болон цахилгаан дамжуулах агаарын шугам авто замын трасст орсон тул эдгээр шугамыг батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх.
4.2	Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
4.3	Цахилгаан дамжуулах агаарын шугамыг кабель шугамаар трасс өөрчлөн зөөх бол 2 талдаа хуурай салгуур бүхий алсын удирдлагатай, УБЦТС ТӨХК-ийн СКАДА системтэй холбогдож ажилладаг реклоузерийн пункт суурилуулах. Реклоузерийн пункт суурилуулах байршлыг ажлын зураг төслийн шатанд тус компанитай зөвшилцөх. 4.3.1) Шинээр суурилуулсан реклоузерийн пунктийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх
4.4	Нэг трассад байгаа кабель шугамуудыг Цахилгаан байгууламжийн дүрэм, ТАД, ААД-ын заалтуудыг хангасан инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барьж байршуулах.
4.5	Инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барих ажлын шийдэл төслийг тус компанийн Техникийн бодлого хэлтэстэй зөвшлцөх.
4.6	Кабель шугамыг шилжүүлэн зөөх хэсэгт байгаа муфтьны байршлын тодруулгыг харьяа ашиглалт засварын төвөөс авч, шугамыг муфтьнаас муфтьны хооронд зөөх асуудлыг барилга угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС ТӨХК-тай зөвшилцөж гүйцэтгэх.

4.7	Авто замын трассын уртын 50 метр тутамд зам хөндлөн ган хоолой суурилуулах. Суурилуулах ган хоолойны байршил, тоо хэмжээг зураг төслийн шатанд тус компанийн техникийн бодлогын хэлтэстэй зөвшилцөх.
4.8	Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сүвлэх ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах.
4.9	Батлагдсан зургийн дагуу зөөж шилжүүлэх шугамын трасс өөрчлөгдөх тохиолдолд харьяа ашиглалт засварын төвөөс дахин тодруулга авч УБЦТС ТӨХК -тай зөвшилцөх.
4.10	Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.
4.11	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа ашиглалт засварын төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
4.12	Авто замын трасст орсон УБЦТС ТӨХК- ийн эзэмшлийн бус цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг шилжүүлэн зөөх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авах ба бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцсөн байх.
4.13	Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг УБЦТС ТӨХК- ийн харьяа ашиглалт засварын төвд актаар хүлээлгэн өгөх.
4.14	Буусан тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
4.15	Зөөж шилжүүлэх цахилгаан дамжуулах шугамын угсралтын зураг төслийг ЦБД-ийн БД 43-101-03-д заасны дагуу зай хэмжээг баримтлан гүйцэтгэх.
4.16	Газар шорооны ажил эхлэхээс өмнө УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд хандаж дахин тодруулга хийлгэх, барилга угсралтын ажлын үед хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
4.17	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцыг шилжүүлэн зөөх ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.18	Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	"Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.4	"Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа ашиглалт засварын төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
5.5	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.6	Нийслэлийн нутаг дэвсгэрт кабель шугам шинээр татах, шинэчлэх, засварлах үед авто зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн тохижилттой зам талбайг сэтлэх, сүвлэх инженерийн шугам сүлжээ хийх, орц гарц гаргах тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авах.
5.7	Шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.8	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.9	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"- ийн 2.17- д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд: 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд. 6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон. 6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд. 6.1.4) Хугацаа дуусан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно 6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дуусан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно. 6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
6.2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.
6.3	Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.

Хавсралт-4

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

ЕРӨНХИЙ

Энэхүү бүлэгт барилгын ажлын үед Хөдөлмөрийн Аюулгүй Байдал болон Эрүүл Ахуйн шаардлагыг хэрхэн хангах тухай тусгасан бөгөөд ХАБЭА –н шаардлагууд нь тухайн байгууллага компани, орчин нөхцөлөөс хамаарч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно. Тухайн ажлын явцад Аюулгүй байдал Хөдөлмөр хамгааллын Инженер болон Ажилтан зайлшгүй байх шаардлагатай бөгөөд тусгайлан бэлтгэгдсэн, сургалтанд хамрагдсан, ажлын туршлага дадлагатай байх шаардлагатай.

Хөдөлмөр хамгааллын инженер өдөр бүр ажил эхлэх бүрт ажилтан, албан хаагчид, машинист механизмын ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгөх ёстой.

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Тус компани нь хөдөлмөрийн стандартыг баримтлан ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийг, ажлын байрны нөхцөл, аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлсэн ба хөдөлмөрийн норм, стандарт өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг баримтална. Ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар мэдлэг олгох сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, биелэлтэд хяналт тавина. Засвар, үйлчилгээ явуулах ажлын байрны агаарын температур, харьцангуй чийглэг, дуу шуугианы хэмжээ, үндсэн ба туслах байрны гэрэлтүүлгийг нь стандартад заасан хэмжээнд байна. Ажлын байранд байгалийн гэрэлтүүлгийн коэффициент 1,5 хувиас багагүй байна. Гэрэлтүүлэг нь ажлын байрны талбарт жигд тархсан, гялбалт үүсэхгүй байх шаардлагатай ба гэрэлтүүлэгчийн үүсгэврийг тогтмол хугацаанд цэвэрлэж байвал зохино. Ажлын байранд тоос, химийн бодис тархахаас сэргийлэн, салхивчийн ерөнхий ба хэсгийн системийг төлөвлөх, ажлын үед агаар сэлгэх төхөөрөмжийг зориулалтын дагуу ажиллуулж байх, агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаанд тогтмол үзлэг хийж, эвдэрсэн тохиолдолд бүрэн засвар хийж цэвэрлэж байвал зохино. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм заавартай, зохих журмын дагуу хөтлөгдсөн техникийн паспорттай ба хөдөлмөрийн хяналтын байгууллагаас ашиглах зөвшөөрлийн гэрчилгээтэй болно. Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна. Ажиллагчдын ахуйн байр нь ариун цэвэр, эрүүл ахуйн норм, стандартыг хангасан байна. Ажилтаны ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан ба ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалтыг баримтлан ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан. Ажилтныг ажилд шинээр ороход эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба тэднийг мэргэжлийн өвчин, архаг хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт зохих журмын дагуу хамруулна.

Хүнд, хүчир ажлыг механикжуулах, автоматжуулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх талаар арга хэмжээ авч, техник технологийн шинэчлэл хийх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ. Ажлын байранд анхан шатны тусламж үзүүлэх аптектай байна.

Галын аюулгүй байдлыг хангах дотоод дүрэмтэй байна. Галын дохиолол, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлган ажилтнуудаа уг тоног төхөөрөмжийг ашиглаж сургасан байх ба галын аюулаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

АЖИЛЧДАД ӨГӨХ ЗААВАРЧИЛГААНЫ ТӨРЛҮҮД

- Өдөр тутмын зааварчилгаа
- Геодезийн бэлтгэл ажил хийх ажлын заавар
- Авто зам, барилгын ажилд геодезийн хэмжилт, боловсруулалт хийх үеийн геодезийн инженер, техникч, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Лабораторийн инженер, техникч, туслах ажилчдын хяналт, шинжилгээ хийх заавар
- Лабораторийн инженер, техникч, туслах ажилчдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Түр зам барих ажлын заавар, аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Хөрс хуулах, төмөр бетон хоолой барих, далан барих, суурь барих, асфальт бетон хучилт барих, цемент бетон хучилт барих, авто замын хөвөө хийх, авто замын тоноглол тохижилтын ажил хийх ажлын зааврууд, аюулгүй ажиллагааны зааварчилгаанууд
- Дизель цахилгаан станцын аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Гагнуурчин, цахилгаанчин, тоног төхөөрөмж машин механизмын засварчны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Үйлдвэрлэлийн багаж хэрэгслийн ажиллуулах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ӨДӨР ТУТМЫН ЗААВАРЧИЛГАА

Ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгааллын хувцсаа бүрэн өмсөж хамгаалах хэрэгслээ бүрэн бүтэн байдлыг нь шалга. Энэ өдөр ажил гүйцэтгэхэд ашиглах багаж, материал бусад шаардлагатай зүйлээ ойртуулж хэрэглэхгүй эд юмсыг ажил хийхэд саад болохооргүй болго.

Цахилгаан, тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт, разеток, унтраалга болон бусад зүйл аюулгүй ажиллагааны шаардлага хангаж байгаа эсэхийг шалга.

Бусад ажилтнаа ажлаа аюулгүй тайван гүйцэтгэхэд саад болохгүй байх ба хөгжим тавих, утсаар ярих зэргээр зэргэлдээх ажилтныхаа анхаарлыг бүү сарниул

Гэнэтийн аюул учирсан үед ажилчид явахад зориулсан зам талбайг чөлөөтэй байлгах, шаардлагатай багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглахад бэлэн байлга.

Галын аюулгүй байдлыг чанд сахиж ил гал гаргах, зориулалтын бус газар тамхи татахыг хатуу хориглоно.

Машин механизмын дээр доор дотор засвар техникийн үйлчилгээ хийхдээ өндрөөс унах, машин механизм хооронд хавчуулагдах, хөл гар бие дээрээ хүнд төмөр багаж, хэрэгсэл унагааж бэртээх, эргэлдэх хөдөлгөөнтэй багаж болох точиль, хөрөө рам, таслагч, сэнс болон бусад багаж төхөөрөмжид ороцолдох, хуруу гараа тастах, автомашины дугуйнд дайрагдах, цахилгаанд цохиулах зэрэг эрсдэлтэй тул техникийн аюулгүйн дүрэм болон инженер механик нарын заавар зөвлөгөөг чанд сахин даган мөрдөж, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж маш анхаарал болгоомжтой ажилла.

Хийн баллон, дизель генератор, гагнуурын аппарат болон шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх бодис зэрэгтэй зөвшөөрөлгүй харьцахыг хориглоно. Шинэ ажлын байранд шилжин ажиллаж байгаа бол хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа, хэрэв аюул осолтой, онцгой болгоомжтой ажиллах ажил гүйцэтгэх гэж байгаа бол өдөр тутмын зааварчилгаа авахаа бүү март.

Мэргэжлийн эрх бүхий ажилтнаас бусад хүмүүс машин, цахилгаан хэрэгсэл, агааржуулалт, гэрэлтүүлгийн болон гал унтраах хэрэгслийг оролдох, засварлах, тохируулгыг өөрчлөх, хаалт хамгаалалт, тэдгээрийн хаяг бичээсийг авахыг тус тус хориглоно.

Талбай дээр автомашины хөдөлгөөнөөс болгоомжил. Авто машиныг ухрах хөдөлгөөн хийж байх үед ард нь зогсохыг хориглоно.

Чулуу үсрэхээс болгоомжилж заавал каск малгайгаа өмс.

Харанхуй болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед ажиллах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд гар чийдэн болон гэрэл ойлгогч хувцастай заавал ажилла.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Жолооч нар нь сүүлийн үеийн Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг мөрдлөг болгоно. Жолооч нь ажилд гарахын өмнө хөдөлгүүрийн масло, тосол тормосны шингэнээ шалгаж хөдөлгүүрийг асаах ба бүх гэрэл дохио, рулийн механизм, тормосыг ажиллагаатай эсэхийг шалгасны дараа л ажилд гарна.
Хөдөлгөөнд оролцохдоо суудлын бүсээ зүүж дуут дохио болон гэрэл шилжүүлэн хөдөлнө. Халтиргаа гулгаатай замд, уулын уруу өгсүүр газар холын гэрэл шилжүүлэн хурдыг зөв тохируулан анхаарал болгоомжтой явах.
Ажиллаж байх үедээ дугуйн даралт ба гайкнуудыг байнга шалгаж байх.
Дугуй авахдаа дамократын хажуугаар урд хойд тэнхлэгт ивээс тулгуур хийхээс гадна дугуйг угсрах, хийлэхдээ нуух үсрэхээс болгоомжилж анхааралтай байх ба хамгаалалт хийх. Самосвалын кузов өргөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийхдээ кузов буухаас хамгаалж зориулалтын тулгуур хийнэ.
Гагнуур хийх үед малгай, нүдний шил зэрэг хамгаалалтын хэрэгслэлийг заавал хэрэглэж занших ба тэжээлийн клемыг салгаж байх.
Тамхины иш асаагуур зэргийг тэсэрч дэлбэрэх бодис, дизель түлшнээс хол байлгаж гал алдахаас сэргийлэх
Жолооч нь тогтоогдсон маршрутаар явах бөгөөд эзэмшиж байгаа техникээ удирдах ажилтны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хувийн болон өөр бусад ажил хийхийг хориглоно. Жолоочийн кабинд тогтоогдсон хэмжээнээс илүү хүн, гадны хүн тээх, кузов дээр зориулалтын бус ачаа ачих, хүн суулган тээвэрлэхийг хориглоно.
Засвар үйлчилгээ хийхдээ зөвхөн тохирсон багаж түлхүүр хэрэглэх ба ажлын шаардлага хангахгүй эрсдэлтэй багаж түлхүүр хэрэглэхийг хориглоно.
Грейдерийг ажиллуулж байхдаа заавал суудлын даруулгыг хэрэглэнэ. Хутга булагдсан, саад бартааг цохиж болзошгүй.
Ажилд гарахдаа хутгыг их биетэй 30 градусын өнцөг үүсгэн эргүүлж дээш татсан байна.
Түр буюу удаан зогсох, кабинаас буух зэрэг тохиолдолд зам чөлөөлж зогсох ба заавал гар тормос татсан байна.
Гэнэтийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу зам чөлөөлж зогсох ба боломжгүй тохиолдолд ослын зогсолтын тэмдэг тавьж нэн даруй ИТА-д мэдэгдэнэ.
Автогрейдер ба грейдерийг мод, хожуул, том, хад чулуутай газар ажиллуулахыг хориглох ба эргэлтийн үед хурд хамгийн бага байна.
Техникийн засвар үйлчилгээг хазгай налуу, уруу газар хийхийг хориглоно.

Кран, Индүү, Асфальт дэвсэгчийн оператор нарт

Ажилд гарахын өмнө бүх эд анги агрегатуудын ажиллагаанд ямар нэг өөрчлөлттэй эсэхийг шалга. Өргөх ачаа нь краны даацаас хэтрэхгүй байх, ажиллуулж байгаа үед анхаарлаа сарниулахгүй байх ба эргэх үедээ орчин тойрноо сайн ажиглаж дуут дохио өгч байх. Гидрийн шингэний хэмийг байнга үзэж байх. Мөн троосыг мушгихгүй байлгах
Салхины хурд 10м\с-ээс илүү бол кранаар ажил хийхийг хориглоно.
Краныг зөвхөн дохиочны гарын дохиогоор ажиллуулна.
Кранаар ачааг хөндлөн чирэх, татаж зөөж болохгүй ба краныг тэгш гадаргуутай хатуу газар байрлуулж домакратыг заавал сунгаж түгжсэний дараа ажиллуулна.
Краны товчлуурыг зааврын дагуу зөв хэрэглэнэ.
Халуун асфальт бетон, битум нь хүний биед онцгой аюултайг санаж болгоомжил
Замын сул далан нурахаас болгоомжил. Шат гишгүүрээс халтирах, явж байхад бууж суухыг хориглоно.
Ухрах хөдөлгөөн хийхдээ дохио байнга өгөх, тавцан дээр хүн суулгахыг хориглоно. Самосвал, автогрейдерийн ухрах хөдөлгөөнөөс болгоомжил
Авто машинд ямар нэг гэмтэл гарсан тохиолдолд механикт тэр дор нь мэдэгдэж байх. Жолооч нар тээвэр хийхдээ улсын болон орон нутгийн зөвшөөрөгдсөн замаар явж байх, шинээр зам гаргахыг хориглоно. Хүйтний нөхцөлд хөдөлгүүрийн тос гэсгээх зориулалтаар задгай гал түлэхийг хориглоно. Эцэж ядарсан, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед машин жолоодохыг хориглоно. Хазгай налуу газар подъём өргөх, засвар үйлчилгээ хийхийг хориглоно.
Гүйцэж түрүүлэх үйлдлийг гүйцэтгэхдээ замын нөхцөл байдал, онцлогийг харгалзан туйлын анхаарал болгоомжтой замын хөдөлгөөний дүрэмд заагдсан хэм хэмжээг баримтлан гүйцэтгэнэ.
Ажлын талбарт тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаар 50км\ц ба объектын орчим 20 км\ц-аас хэтрүүлэхгүй байна.

МЕХАНИЗМЫН ОПЕРАТОРЧ НАРТ ӨГӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Замын машин механизмын оператор нь ашиглалтын техникийн аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдөн ажиллах ба зориулалтын ажлын хувцас, багаж хэрэгслэлээр хангагдсан, түүнийгээ хэрэглэдэг байх.
Ерөнхий инженер эсвэл механик инженер тухайн техникийг ажиллуулах зөвшөөрөл өгөөгүй байхад түүн дээр ажиллуулахыг хориглоно.
Цахилгаанаар ажилладаг багажийг газардуулагчгүй, мөн хөдөлгөөнт эд анги түүний хэсгийг хаалт таглаагүй буюу эвдэрсэн хаалт таглаатай үед машин механизм дээр ажиллахыг хориглоно.

Грейдерийн аюулгүй ажиллагаа

Ажлаа эхлэхийн өмнө техникийг асааж гэрэлтүүлэг, гэрэл, дохио, дуут дохио, жолоодлогын механизм, тормос зэргийн бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэхийг шалган гарсан гэмтлийг ИТА-д мэдэгдэж арилгуулна.
Шатахуун авах ба, засвар үйлчилгээ хийдээ хөдөлгүүрийг заавал унтрааж тормос татсан байна.
Машин механизмын дээр доор дотор засвар техникийн үйлчилгээ хийхдээ өндрөөс унах, машин механизм дотор хавчуулагдах, хөл гар бие дээрээ хүнд төмөр багаж хэрэгсэл унагааж бэртээх, сэнс болон багаж төхөөрөмжид ороолцолдох, автомашины дугуйнд дайрагдах, цахилгаанд цохиулах зэрэг эрсдэлтэй тул техникийн аюулгүйн дүрэм болон инженер механик нарын заавар зөвлөгөөг чанд сахин даган мөрдөж, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалж маш анхаарал болгоомжтой ажиллана.

Хавсралт-5

ХАЛТИРГААНААС ХАМГААЛАХ ТҮРХЛЭГИЙН ЗУРВАСЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА:

1.Халтргаанаас хамгаалах тусгай хучилт нь замын гадаруун барьцалдах чадварыг нэмэгдүүлэх.

2.Тусгайлсан орчинд өндөр температурт үйлдвэрлэсэн керамик, тусгай цавуунуудыг ашиглан хучилтыг хийх.

3.Хучилт хийх замын гадаргуу /асфальт, бетон, чулуу/ нь эвдрэл гэмтэлгүй, зах ирмэг нь хөндий биш, харьцангуй тэгш, 25-30 градусаас бага налуу, шороо, тоос, химийн бодис зэрэгт бохирдоогүй, хуурай болгож хучилт хийх.

4.Тусгай хучилт хийхээс өмнө замын гадаргууд хуурай цэвэрлэгээг үе шаттай хийх бөгөөд бохирдсон байдлаас хамаарч тусгай цэвэрлэгээний бодистой нойтон цэвэрлэгээ, даралтаар үлээх цэвэрлэгээ зэргийг хийн бүрэн хатаах.

5.2 төрлийн цавууг технологийн дагуу тусгай машинаар хольж, тодорхой температурт халаан, замын гадаргууд жигд байршуулна.

6.Өнгөт керамикийг 1.5-5мм-ийн хэмжээтэй суулгаж бэхжүүлнэ. Бэхжих хугацаа 20-24цаг байх шаардлагатай.

7.Тусгай хучилт хийгдэх, бэхжих үеийн агаарын температур цельсийн +5 градусаас багагүй байх шаардлагатай.

9.Халтиргааны эсрэг хучилт нь дараах үзүүлэлттэй байна.

-Материалын ширхэглэлийн хэмжээ -1.6-4мм байна.

-Шахаотын бат бэх – 800-1200кг/см2

-Асгаасан нягт – 2100-2400кг/м3

-Дундаж асгаасны давхаргын зузаан 2 250-350мкм

- Дагуу налуу 8%-10% хүртэлх хэсэгт халтиргаанаас хамгаалах түрхлэгийг 3м урттай тэмдэглэгээ хоорондын зай 5м байхаар хийх.
- Халтиргаанаас хамгаалах түрхлэг нь зорчих хэсгийн 7м өргөнд 3м урттай байна.

Хавсралт-6

АВТО ЗАМЫН ӨВЛИЙН АРЧЛАЛТ

Авто замын өвлийн арчилгаа нь аюулгүй байлгах, зорчих нөхцөлийг сайжруулах зорилготой байдаг. Энэ нь олон төрлийн арга хэмжээ, тоног төхөөрөмж, материалуудыг хэрэглэнэ.

Үүнд:

-**Мөс цэвэрлэх тоног төхөөрөмж:** Цас цэвэрлэх комбайн, снегоочигч машин ашиглана. Мөн өвлийн улиралд зам дээр мөс тогтсон хэсгийг механикаар арилгадана.

-**Хлорид, натрийн давс (Мөс хайлуулах):** Энэ нь замыг хальтиргаанаас хамгаалж, мөс хайлуулах зориулалттай. Давс, хлорид, магнийн хлорид зэргийг ашигладаг.

-**Эко найрлага:** Зарим газруудад байгаль орчинд хоргүй, эко найрлагатай давс ашиглахыг илүүд үздэг.

Зам хариуцагч компани нь өвлийн улиралд гэнэтийн нөхцөлд ч хариу арга хэмжээ авахад бэлэн байх шаардлагтай. Мөн авто замын бэлэн байдлыг хангах үүднээс хайрцагтай элс, хайрга, давс гэх мэт барьцалдалт сайжруулах материал байрлуулах боломжтой байна.

Халтиргаанаас хамгаалах түрхлэгийн нарийвчилсан хэмжээсийн зураг



ТАНИХ ТЭМДЭГ

Одоо байгаа авто зам

Төлөвлөж буй авто зам

ГЕО УРБАН КОНСАЛТИНГ	УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ 3, 4-Р ХОРООНЫ ГОЛЫН АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ			Авто зам	
	Захирал	И.Өсөхбаяр	Байршилын схем	Масштаб	
	Зур.инж	Б.Билэгжаргал		үе шат	хуудас / бүх хуудас
	Гүйцэтгэсэн	А.Батбаяр		А3	1 / 1
"ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"ХХК	Шалгасан	Б.Билэгжаргал	Шифр: ГУК-12/25	2025 оны 4-р сар	



ТАНИХ ТЭМДЭГ

- Шинээр төлөвлөсөн авто зам
- Байшин
- Хүчитгэх хавтан
- Төлөвлөж буй явган зам
- Гадаргуун ус зайлуулах шугам
- Цэвэр усны шугам
- Мэдээлэл холбооны шугам
- Гэрэлтүүлэг
- Ариутгал татуургын шугам
- Цахилгааны шон
- Газар доорх цахилгааны шугам
- Шүүрт худаг

ГЕО УРБАН КОНСАЛТИНГ "ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"ХХК	УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ 3, 4-Р ХОРООНЫ ГОЛЫН АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ			Авто зам
	Захирал	И.Өсөхбаяр	Дэвсгэр зураг	Масштаб 1:500
	Зур.инж	Д.Баасансүрэн		үе шат / хуудас / бүх хуудас
	Гүйцэтгэсэн	А.Батбаяр		А3 / 1 / 5
	Шалгасан	Б.Билэгжаргал	Шифр: ГУК-12/25	2025 оны 04-р сар



ТАНИХ ТЭМДЭГ

- Шинээр төлөвлөсөн авто зам
- Байшин
- Цэвэр усны шугам
- Төлөвлөж буй явган зам
- Гадаргуун ус зайлуулах шугам
- Ариутгал татуургын шугам
- Мэдээлэл холбооны шугам
- Гэрэлтүүлэг
- Шүүрт худаг
- Цахилгааны шон
- Газар доорх цахилгааны шугам

ГЕО УРБАН КОНСАЛТИНГ "ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"ХХК	УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ 3, 4-Р ХОРООНЫ ГОЛЫН АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ			Авто зам
	Захирал	И.Өсөхбаяр	Дэвсгэр зураг	Масштаб 1:500
	Зур.инж	Д.Баасансүрэн		үе шат / хуудас / бүх хуудас
	Гүйцэтгэсэн	А.Батбаяр		А3 / 2 / 5
	Шалгасан	Б.Билэгжаргал	Шифр: ГУК-12/25	2025 оны 04-р сар

ТАНИХ ТЭМДЭГ

- Шинээр төлөвлөсөн авто зам
- Байшин
- Цэвэр усны шугам
- Төлөвлөж буй явган зам
- Гадаргуун ус зайлуулах шугам
- Ариутгал татуургын шугам
- Мэдээлэл холбооны шугам
- Гэрэлтүүлэг
- Шүүрт худаг
- Цахилгааны шон
- Газар доорх цахилгааны шугам

ГЕО УРБАН КОНСАЛТИНГ	УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ 3, 4-Р ХОРООНЫ ГОЛЫН АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ			Авто зам
	Захирал	И.Өсөхбаяр	Дэвсгэр зураг	Масштаб 1:500
	Зур.инж	Д.Баасансүрэн		үе шат / хуудас / бүх хуудас
	Гүйцэтгэсэн	А.Батбаяр		А3 / 3 / 5
"ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"ХХК	Шалгасан	Б.Билэгжаргал	Шифр: ГУК-12/25	2025 оны 04-р сар

ТАНИХ ТЭМДЭГ

- Шинээр төлөвлөсөн авто зам
- Байшин
- Цэвэр усны шугам
- Төлөвлөж буй явган зам
- Гадаргуун ус зайлуулах шугам
- Ариутгал татуургын шугам
- Мэдээлэл холбооны шугам
- Гэрэлтүүлэг
- Шүүрт худаг
- Цахилгааны шон
- Газар доорх цахилгааны шугам

ГЕО УРБАН КОНСАЛТИНГ "ГЕО УРБАН КОНСАЛТИНГ"ХХК	УЛААНБААТАР ХОТ, НАЛАЙХ ДҮҮРЭГ 3, 4-Р ХОРООНЫ ГОЛЫН АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ			Авто зам
	Захирал	И.Өсөхбаяр	Дэвсгэр зураг	Масштаб 1:500
	Зур.инж	Д.Баасансүрэн		үе шат / хуудас / бүх хуудас
	Гүйцэтгэсэн	А.Батбаяр		А3 / 4 / 5
	Шалгасан	Б.Билэгжаргал	Шифр: ГУК-12/25	2025 оны 04-р сар